



БАТЛАВ  
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ  
ДАРГА *Ё. РЭНЦЭНДОРЖ*  
20*20* оны *08* сарын *17* ны өдөр

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН 1 ДҮГЭЭР БАГИЙН НУТАГ  
ГОРХИНД ГҮН ӨРМИЙН ХУДАГ ГАРГАХ  
АЖ АХУЙН НЭГЖИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ  
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

ӨЛЗИЙТ СУМ

2020 ОН

## **Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА**

Огноо:2020.09.02

Тендер шалгарулалтын нэр: 1 дүгээр багд гүний худаг шинээр гаргах ажлын тендер

Тендер шалгаруулалтын дугаар: ӨВАБӨСЗДТГ/202001015

Өвөрхангай аймгийн Өлзийт сумын ЗДТГ нь эрх бүхий тендерт оролцогчдоос 1 дүгээр багд гүний худаг шинээр гаргах ажлыг гүйцэтгэх тухай цахим тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.Тендер шалгаруулалтын Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан“Цахим тендер шалгаруулалтын журам”-ын дагуу зохион байгуулагдаж байна.

Тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авах боломжтой бөгөөд тендерт оролцохын тулд эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000 /тавин мянган/ төгрөг цахим тендерийн хураамж төлнө.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэх 30 хоног хүчинтэй байна.

**Тендерт оролцогч нь:** Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. **Үүнд:**

- **Борлуулалтын хэмжээ:** 2019 оны борлуулалтын орлого төсөвт өртгийн 20 хувиас багагүй байх

- **Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ нь төсөвт өртгийн 20 хувиас багагүй

- **Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** 2019 он

- **Сүүлийн нэг жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** 2019 онд төсөвт өртгийн 20 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг гүйцэтгэсэн байна

- **Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:** Тийм

Тендерийг **2020 оны 10 -р сарын 09 -ны өдрийн 10 цаг 00 минут** -аас өмнө

ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 10 -р сарын 09-ны өдрийн 10 цаг 30 минут** -т нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх: **Тооцохгүй**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Өвөрхангай Өлзийт сумын ЗДТГ**

**Утас 88245130, 99329338**

Имэйл хаяг: [Ulziit](mailto:Ulziit@ov.gov.mn)

[@ov.gov.mn](mailto:ov.gov.mn)

Вэб сайт: [Ulziit.ov.gov.mn](http://Ulziit.ov.gov.mn)

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

### 1. Эрх бүхий тендерт оролцогч

- 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-заасан холбогдох шаардлагыг хангасан байна.

### 2. Тендер ирүүлэх тендерийн нээлт

- 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
- 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

### 3. Тендерийн иж бүрдэл

3.1. Тендерт оролцогчдоод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:

- (а) Үнийн санал;
- (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
- (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
- (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
- (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]

### 4. Тендерийн үнэ

- 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
- 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
- 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
- 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.

### 5. Үнийн саналын хүчинтэй

5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

### 6. Алдааг залруулах

6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:

- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийтүнийг залруулна;
- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.

#### **7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**

7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.

7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

#### **8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

### **Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ ТӨӨЗ-НЫ ХОЛБОГДОХ ЗААЛТ**

#### **ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

##### **ТӨӨЗ 1.1 2019 оны жилийн санхүүгийн тайлан**

[/www.mof.gov.e-balance.mn](http://www.mof.gov.e-balance.mn) цахим бүртгэлд шивэгдэн баталгаажсан байх/

- **Сүүлийн /2018, 2019 аль нэг оны/ туршлагын мэдээлэл** /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбарыг наториатаар баталгаажуулсан байх, захиалагчийн тодорхойлолт, акт/

- **Бусад нэмэлт шаардлага:**

**1. ААНБайгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /нотариатаар баталгаажуулсан байх/**

**2. Сүүлийн нэг жилд ашигтай ажилласан байх /Борлуулалтын орлого тухайн тендерийн төсөвт өртгийн 20 хувиас багагүй/**

**3. Харилцагч банкнуудын тодорхойлолт**

**4. Харьяа татвар, нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт**

- **Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ/ барилга хот байгуулалтын яамны**

**2.2.4, 2.3.1, 2.3.2, заалтын дагуу зөвшөөрөлтэй байх, хуулбарыг нотариатаар баталгаажуулсан байх/**

**Тендерт оролцогч ААНБ нь:**

**1. Тендерт оролцогч боловсруулсан тендерийн иж бүрдэл, баримт бичгийг электрон хэлбэр /Adobe PDF/ -т хөрвүүлж цахим хэлбэрээр ирүүлнэ.**

**2. Уг тендер нь цахим тендер шалгаруултын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч ААНБ нь төрийн худалдан авах систем /www.tender.gov.mn/ -д ААНБ нт өөрийн**

**цахим гарын үсэг /PKI/-аар нэвтрэн орж тендерийн бичиг баримтыг цахимаар авч, бэлтгэсэн тендерийн бичиг баримтаа цахим хэлбэрээр ирүүлнэ.**

**3. Захиалагч шалгарсан тендерт оролцогч ААНБ-ын мэдээлэл болон санхүүгийн мэдээллийг олон нийтэд мэдээллэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан тоот ирүүлэх**

**ТООЗ 2.1 Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:**

**Байгууллагын хаяг: Өвөрхангай аймгийн Өлзийт сум, 2-р баг, ЗДТГ,**

**Огноо: 2020 оны 09 сарын 23-ны өдөр Цаг: 10 цаг 00 минут**

**Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим худалдан авах системийн /www.tender.gov.mn/-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийг хүлээн авах боломжгүй.**

**ТООЗ 2.2 Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:**

**Байгууллагын хаяг: Өвөрхангай аймгийн Өлзийт сум, 2-р баг,**

**ЗДТГ, Утас: 882451303, 99329338**

**Огноо: 2020 оны 10 сарын 09 ны өдөр**

**Цаг: 10 цаг 30 минут**

**ТООЗ 6.2 Энэхүү тендер шалгаруулалт нь багцгүй.**

**Төсөвт өртөг: 13020300 /арван гурван сая хорин мянга гурван зуун . төгрөг /**

**Инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргах ажлын техникийн тодорхойлолт**

**Захиалагчийн нэр Өвөрхангай аймгийн Өлзийт сумын ЗДТГ**

**Бараа, ажил, үйлчилгээний нэр**

**1 дүгээр багд гүн өрөмийн худаг шинээр гаргах**

**Тендер шалгаруулалтын дугаар ӨВАӨЛСЗДТГ/202001004**

**Техникийн тодорхойлолт:**

**А. Зориулалт Ундны ус,**

**Б.Хэрэглээ Айл, өрхүүд ундны ус авах, малаа услах**

**В. Ашиглалт Жилийн 4 улиралд**

**Г. Чанарын түвшин Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж**

**суурилуулах ажилд тавих техникийн шаардлага MNS6088:2010**

**стандартыг бүрэн хангасан орчин үеийн технологи ашигласан,**

**чанартай материалаар хийгдсэн, эдэлгээ даах чадвартай, иргэдийн**

**сэтгэл санаанд нийцэхүйц, олон жилийн баталгаатай, байгаль орчинд**

**хор нөлөөгүй байна.**

**Д. Техникийн үзүүлэлт Ус ашиглалт цооногийн хийц зохиомж нь**

**MNS6088:2010**

**стандартад бүрэн нийцсэн, ашиглалтын үеийн ундарга нь 0.6 л/сек-ээс**

**дээш, 1 цагт 2 м.куб-6м.куб ус өргөх хүчин чадалтай байна. Худгийн**

**барилгын дотор багтаамж 18м.куб-аас багагүй, өнгөлсөн бетон шал,**

**торон хаалт бүхий вакум цонх, сайн чанарын төмөр хаалгатай, бат**

**бөх салхи шуурганд тэсвэртэй материалаар хийгдсэн, дээвэр нь ус,**

**цас, салхинд тэсвэртэй чанарын өндөр түвшинд хийгдсэн байна.**

**Барилгын эргэн тойронд 0.5 м-ээс багагүй бетон хаяавч зутгасан**

**байна. 1.5 м.куб-с багагүй эзэлхүүнтэй эрүүл ахуйн шаардлага хангасан,**

**бат бөх усан сан, халаах зуух, цооногоос усан сан, ундны ус авах уян хоолой буюу цоргийг өндөр нам болгох шийдэлтэй хийсэн байна. Ус шахуурга, цахилгаан үүсгүүр нь өндөр хүчин чадалтай, барааны гарал үүслийн тодорхойлолт, ашиглалтын заавар Монгол хэл дээр байна. Барилгатоног төхөөрөмж нь олон улсын болон үндэсний стандартад нийцсэн, барилга байгууламжийн норм, нормативыг бүрэн хангасан байна.**

**Е. Тоо хэмжээ Стандартын цооног 1 ширхэг, сайн чанарын өндөр хүчин чадалтай мотор 1 ширхэг, насос 1 ширхэг, 2х3 хэмжээтэй барилга 1 ширхэг, усан сан 1 ширхэг, ус дамжуулах хоолой 1 ширхэг, зуух 1 ширэг, яндан 1 ширхэг, бусад дагалдах төхөөрөмж,**

**Тайлбар: 1 дүгээр багт техникийн тодорхойлолтын дагуу 1 ш гүн өрөмийн худаг баригдана. Төсөв тооцоог нарийн гаргаж ирүүлэхийг анхаарна уу!**

**Долоо. ЖИШИГ МАЯГТ  
ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

**[огноо]**

**(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа**

**1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.**

**2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.**

**3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.**

**4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна. Тендерт оролцогчийн нэр: Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга: Албан тушаал, нэр: Хаяг:**

### **Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ**

**1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх**

**1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.**

**2. Төслийн менежерийн шийдвэр**

**2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.**

**3. Ажил**

**Дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх**

**3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.**

**4. Аюулгүй байдал**

**4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.**

**4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.**

**5. Зааварчилгаа**

**5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй**

**6. Маргааныг шийдвэрлэх**

**6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.**

### **Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ**

**7. Ажлын хөтөлбөр**

**7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатамэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.**

**7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.**

**8. Зөрчил,гологдол илрүүлэх**

**8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн**

**зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.**

**10 Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.**

**9. Зөрчил, гологдол арилгах**

**9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа<sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.**

**9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.**

**10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**

**10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.**

**В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ**

**11. Үе шатны ажлын хуваарь**

**11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.**

**11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.**

**12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**

**12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.**

**13. Алданги 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги<sup>2</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.**

**Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ**

**14. Ажил дуусгах**

**14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод,**

**цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.**

**15. Хүлээж авах**



**15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.**

**16. Эцсийн тооцоо**

**16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.**

**Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.**

**Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.**

**17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**

**17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.**

**17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүн суутгана.**

**18. Гэрээг цуцлах**

**18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.**

**18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:**

**(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;**

**(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;**

**(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;**

**(г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;**

**(д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.**

**18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.**

**19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоорхөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

20. Гүйцэтгэлээс чөлөөлөх

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлынулмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

## ГЭРЭЭНИЙ МАЯГТ

### ЗАХИАЛАГЧ

\_\_\_\_\_

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

\_\_\_\_\_

(Албан тушаал)  
ГҮЙЦЭТГЭГЧ

\_\_\_\_\_

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

\_\_\_\_\_

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....

хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг

харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид

“гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль

тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил

гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн

хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг

тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг

тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн

гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт

төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь

бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд:

\_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_ хүчин чадал бүхий

\_\_\_\_\_ ам.метр талбай / \_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай,

\_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана,

\_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар

барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг

\_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан

хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_

14

оны \_\_\_ дугаар сарын \_\_\_-ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_ дугаар сарын \_\_\_-ны өдөр

ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;

5.3. Үнийн санал

5.4. Гэрээний тусгай нөхцөл;

5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;

5.6. Техникийн тодорхойлолт;

5.7. Зураг;

5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :

5.9. Санхүүжилтийн хуваарь;

5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн

тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг

баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч

шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан

эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн

энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж,

зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг

гүйцэтгэгчид төлөх үүрэг,

хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын

үсэг] \_\_\_\_\_

**ТАМГА**

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын

үсэг] \_\_\_\_\_

**ТАМГА**

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар\_\_